



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/186

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV дүгээр хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2023 оны XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган сумын Рашаант багт цэвэр усан хангамжийн нэгдсэн системийг шинээр байгуулах зураг төсөв боловсруулах ажлыг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр “Их мянган инженерчлэл” ХХК-тай гэрээ шууд байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Их мянган инженерчлэл” ХХК (Д.Даваажаргал)-д үүрэг болгосугай.

3. Булган сумын Рашаант багт цэвэр усан хангамжийн нэгдсэн системийг шинээр байгуулах зураг төсөв боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж хүлээн авахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн байгаль хамгаалах сангийн тухайн төсөл арга хэмжээний батлагдсан төсвөөс гэрээнд заасан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг сангийн нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

8873010152